



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/113/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Р.Цанжидмаа Утас: 99029885 Цахим хаяг: tsania.0215@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
3. Аудитын тайлан .....	8
3.1 Ерөнхий зүйл .....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	9
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	12
4. Аудитын илрүүлэлт.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ЕСӨНБУЛАГ СУМЫН 7 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Б.НАРАНЦЭЦЭГ ТАНАА

## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.25 № 81

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Есөнбулаг сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Үр дүнгийн урамшуулал илүү олгосон, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтсан, төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр тавилга эд хогшил худалдан авсан, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй зэрэг 6.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь: Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" журам, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй

07122886


баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1.00</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>24,071,442.10</b>	<b>52,568,072.10</b>
<b>35.00</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	24,071,442.10	52,568,072.10
<b>351.00</b>	<b>Түүхий эд материал</b>	259,960.00	10,943,200.00
35,110.00	Тусгай зориулалттай материал	35,000.00	10,485,000.00
35,130.00	Эм боох материал	224,960.00	458,200.00
<b>354.00</b>	<b>Хангамжийн материал</b>	23,811,482.10	41,624,872.10
35,410.00	Бичиг хэргийн материал	255,600.00	209,600.00
35,420.00	Аж ахуйн материал	22,393,682.10	26,330,332.10
35,460.00	Хүнсний материал	113,100.00	220,840.00
35,470.00	Бусад хангамжийн материал	1,049,100.00	14,864,100.00
<b>2.00</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>52,970,632.39</b>	<b>88,489,170.04</b>
<b>39.00</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	52,970,632.39	88,489,170.04
<b>392.00</b>	<b>Биет хөрөнгө</b>	52,670,632.39	88,264,170.04
39,201.00	Барилга, байгууламж, орон сууц	5,340,000.00	5,340,000.00
39,202.00	Хуримтлагдсан элэгдэл	(2,395,000.00)	(4,089,999.92)
39,205.00	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,595,214.00	55,595,214.00
39,206.00	Хуримтлагдсан элэгдэл	(9,414,835.67)	(16,168,448.73)
39,207.00	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,638,373.00	45,638,373.00
39,208.00	Хуримтлагдсан элэгдэл	(6,093,118.94)	(10,417,808.30)
39,214.00	Бусад үндсэн хөрөнгө	-	12,470,763.00
39,215.00	Хуримтлагдсан элэгдэл	-	(103,923.01)
<b>393.00</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	300,000.00	225,000.00
39,301.00	Програм хангамж	300,000.00	300,000.00
39,302.00	Хуримтлагдсан элэгдэл		(75,000.00)
<b>3.00</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>77,042,074.49</b>	<b>141,057,242.14</b>
<b>5.00</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>77,042,074.49</b>	<b>141,057,242.14</b>
<b>51.00</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	77,042,074.49	141,057,242.14
<b>512.00</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	77,042,074.49	141,057,242.14
51,210.00	Өмнөх үеийн үр дүн	58,610,265.49	77,042,074.49
51,220.00	Тайлант үеийн үр дүн	18,431,809.00	64,015,167.65
<b>6.00</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>77,042,074.49</b>	<b>141,057,242.14</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.00	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>290,397,809.00</b>	<b>350,737,343.00</b>
12.00	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>18,844,309.00</b>	<b>13,149,943.00</b>
120.00	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	18,844,309.00	13,149,943.00
120,004.00	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,844,309.00	13,149,943.00
1,200,045.00	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,844,309.00	13,149,943.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан Орлого-Үндсэн хөрөнгө		12,470,763.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		679,180.00
13.00	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>271,553,500.00</b>	<b>337,587,400.00</b>
1,310.00	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	256,463,700.00	315,799,400.00
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	256,463,700.00	315,799,400.00
131,104.00	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,287,844.00	
1,320.00	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	15,089,800.00	21,788,000.00
132,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	15,089,800.00	21,788,000.00
2.00	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>275,503,844.00</b>	<b>286,722,175.35</b>
21.00	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>275,503,844.00</b>	<b>286,722,175.35</b>
210.00	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	259,492,120.77	280,201,429.72
2,101.00	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	204,581,531.77	205,969,869.45
210,101.00	Үндсэн цалин	194,513,459.77	201,904,579.35
210,104.00	Урамшуулал	10,068,072.00	4,065,290.10
2,102.00	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25,572,738.00	26,540,782.77
210,201.00	Тэтгэврийн даатгал	19,435,322.30	18,307,075.77
210,202.00	Тэтгэмжийн даатгал	-	2,058,478.00
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	1,636,623.50	1,646,781.00
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	409,164.10	411,496.00
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	4,091,628.10	4,116,952.00
2,103.00	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,623,166.00	13,288,000.00
210,302.00	Түлш, халаалт	12,623,166.00	13,288,000.00
2,104.00	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,970,300.00	4,019,307.15
210,401.00	Бичиг хэрэг	549,400.00	396,000.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000.00	994,807.15
210,404.00	Ном, хэвлэл	-	83,000.00
210,405.00	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	236,000.00	166,000.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	909,900.00	2,379,500.00
2,105.00	<b>Нормативт зардал</b>	12,031,885.00	9,585,895.00
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	120,000.00	485,540.00
210,502.00	Хоол, хүнс	11,911,885.00	9,100,355.00
2,106.00	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,500,000.00	6,534,250.00
210,604.00	Урсгал засвар	1,500,000.00	6,534,250.00
2,108.00	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	544,000.00	1,161,100.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	513,100.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210,806.00	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2,109.00	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	668,500.00	13,102,225.35
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	668,500.00	150,000.00
210,903.00	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	12,952,225.35
213.00	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	16,011,723.23	6,520,745.63
2,132.00	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,378,844.00	1,520,000.00
213,208.00	Хөдөө орон нутагт тогтвор суурьжилтаи ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,287,844.00	
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,091,000.00	1,520,000.00
2,134.00	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	966,634.00	-
213,403.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	966,634.00	
2,135.00	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	10,666,245.23	5,000,745.63
213,503.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,666,245.23	5,000,745.63
3.00	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>14,893,965.00</b>	<b>64,015,167.65</b>
5.00	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>14,893,965.00</b>	<b>64,015,167.65</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	77,042,074.49	0.00	77,042,074.49
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	77,042,074.49	0.00	77,042,074.49
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	77,042,074.49	0.00	77,042,074.49
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	77,042,074.49	0.00	77,042,074.49
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	77,042,074.49	0.00	77,042,074.49
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	64,015,167.65	0.00	64,015,167.65
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	141,057,242.14	0.00	141,057,242.14

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1.00</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>274,841,344.00</b>	<b>337,587,400.00</b>
<b>13.00</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>274,841,344.00</b>	<b>337,587,400.00</b>
<b>1,310.00</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	256,463,700.00	315,799,400.00
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	256,463,700.00	315,799,400.00
<b>1,330.00</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	15,089,800.00	21,788,000.00
133,001.00	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,089,800.00	21,788,000.00
<b>2.00</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>274,841,344.00</b>	<b>301,587,400.00</b>
<b>21.00</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>274,841,344.00</b>	<b>301,587,400.00</b>
<b>210.00</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>258,829,620.77</b>	<b>295,066,654.37</b>
<b>2,101.00</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	204,905,331.03	205,559,431.17
210,101.00	Үндсэн цалин	187,010,275.11	187,304,483.06
210,104.00	Урамшуулал	17,895,055.92	18,254,948.11
<b>2,102.00</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25,248,938.74	26,951,221.05
210,201.00	Тэтгэврийн даатгал	19,188,393.74	18,832,837.92
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	2005644.56
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	1,616,147.00	1,647,514.88
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	404,038.00	405,930.97
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	4,040,360.00	4,059,292.72
<b>2,103.00</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	12,623,166.00	13,288,000.00
210,302.00	Түлш, халаалт	12,623,166.00	13,288,000.00
<b>2,104.00</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,380,900.00	5,233,807.15
210,401.00	Бичиг хэрэг	579,900.00	350,000.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,000.00	994,807.15
210,404.00	Ном, хэвлэл	80,000.00	83,000.00
210,405.00	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	236,000.00	166,000.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,210,000.00	3,640,000.00
<b>2,105.00</b>	<b>Нормативт зардал</b>	10,947,285.00	23,773,095.00
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	344,960.00	650,000.00
210,502.00	Хоол, хүнс	10,232,325.00	9,208,095.00
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	370,000.00	13,915,000.00
<b>2,106.00</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,500,000.00	8,500,000.00
210,604.00	Урсгал засвар	1,500,000.00	8,500,000.00
<b>2,108.00</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	544,000.00	1,161,100.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		513,100.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210,806.00	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
<b>2,109.00</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	680,000.00	10,600,000.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	680,000.00	10,600,000.00
<b>213.00</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>16,011,723.23</b>	<b>6,520,745.63</b>
<b>2,132.00</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,378,844.00	1,520,000.00
213,208.00	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	3,287,844.00	
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,091,000.00	1,520,000.00
<b>2,134.00</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	966,634.00	-
213,403.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	966,634.00	
<b>2,135.00</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	10,666,245.23	5,000,745.63
213,503.00	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,666,245.23	5,000,745.63
<b>3.00</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-</b>	<b>36,000,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>0.00</b>	<b>36,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.00</b>	<b>36,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.00</b>	<b>36,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		36,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0.00</b>	<b>(36,000,000.00)</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2.00</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	337,587,400.00	332,586,654.37
<b>21.00</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	337,587,400.00	332,586,654.37
<b>210.00</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	336,067,400.00	331,066,654.37
<b>2,101.00</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	207,034,000.00	205,559,431.17
210,101.00	Үндсэн цалин	189,577,000.00	187,304,483.06
210,104.00	Урамшуулал	17,457,000.00	18,254,948.11
<b>2,102.00</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,662,800.00	26,951,221.05
210,201.00	Тэтгэврийн даатгал	19,415,600.00	18,832,837.92
210,202.00	Тэтгэмжийн даатгал	2,037,800.00	2,005,644.56
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	1,673,200.00	1,647,514.88
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	412,600.00	405,930.97
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	4,123,600.00	4,059,292.72
<b>2,103.00</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,288,000.00	13,288,000.00
210,302.00	Түлш, халаалт	13,288,000.00	13,288,000.00
<b>2,104.00</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,035,000.00	5,233,807.15
210,401.00	Бичиг хэрэг	350,000.00	350,000.00
210,402.00	Тээвэр, шатахуун	240,000.00	
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,539,000.00	994,807.15
210,404.00	Ном, хэвлэл	100,000.00	83,000.00
210,405.00	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариут	166,000.00	166,000.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,640,000.00	3,640,000.00
<b>2,105.00</b>	<b>Нормативт зардал</b>	25,786,500.00	23,773,095.00
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	650,000.00	650,000.00
210,502.00	Хоол, хүнс	11,221,500.00	9,208,095.00
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,915,000.00	13,915,000.00
<b>2,106.00</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	44,500,000.00	44,500,000.00
210,601.00	Багаж, техник, хэрэгсэл	19,000,000.00	19,000,000.00
210,602.00	Тавилга	17,000,000.00	17,000,000.00
210,604.00	Урсгал засвар	8,500,000.00	8,500,000.00
<b>2,108.00</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур</b>	1,161,100.00	1,161,100.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	513,100.00	513,100.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
<b>2,109.00</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,600,000.00	10,600,000.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,600,000.00	10,600,000.00
<b>213.00</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,520,000.00	1,520,000.00
<b>2,132.00</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,520,000.00	1,520,000.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,520,000.00	1,520,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	337,587,400.00	332,586,654.37
<b>1,310.00</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	315,799,400.00	310,798,654.37
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	315,799,400.00	310,798,654.37
<b>1,320.00</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	21,788,000.00	21,788,000.00
132,001.00	Орон нутгийн төсвөөс	21,788,000.00	21,788,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Есөнбулаг сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай салбар аудитор Р.Цанжидмаа гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер Д.Эрдэнэчимэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх, хүүхдийг бие бялдарын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх ариун цэвэр эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгох, хэл яриа сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх хүрээлэн байгаа орчин юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Харин Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлийг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Есөнбулаг сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 293.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 5.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 4.7 сая төгрөгөөр тогтоосон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Есөнбулаг сумын 7 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1.8 хувиар буюу 62.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 52.6 сая төгрөг болж 28.5 сая төгрөгөөр өссөн нь хангамжийн материал, тусгай зориулалтын материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 46.9 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 0.7 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 19.0 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 119.3 сая төгрөг болж 40.7 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 36.0 сая төгрөг, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 58 дугаар тогтоолоор 12.5 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлого авсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 139.6 сая төгрөг болж 62.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 1.19 хувиар буюу 57.1 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 62.6 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 387.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 49.9 сая төгрөгөөр бууруулж, 337.6 сая төгрөгөөр баталжээ.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 337.6 сая төгрөгийн төсөв баталснаас 315.8 сая төгрөгийг улсын төсвөөс 21.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 315.8 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 21.8 сая төгрөг нийт 337.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 332.6 сая төгрөгийг зарцуулж 5.0 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 332.6 сая төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 1.5 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 0.7 сая төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 0.8 сая төгрөгөөр, нормативт зардлыг 2.0 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй байна.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

## **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим системд 750.6 сая төгрөгийн 150 мэдээллийг ил тод байршуулахаас 727.4 сая төгрөгийн 130 мэдээллийг ил тод

байршуулсанаас 352.9 сая төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 23.2 сая төгрөгийн 2 мэдээллийг ил тод байршуулаагүй байна.

Горим сорил хэрэгжүүлсэний үр дүнд шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 3.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг биелүүлсэн байна. Харин Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил давтан гарсан.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн жилийн аудитаар

- Төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийн чанар, ашиглалтын байдал
- Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Нягтлан бодох бүртгэлийн дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийн шинж чанар, үнэнд дүн шинжилгээ хийх

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.4 сая төгрөгийн алдаа залруулж, 0.3 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний талаар албан шаардлага, шилэн дансны хэрэгжилтийн талаар зөвлөмж хүргүүлээ.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад Дэлхийн зөн Монгол ОУБ-ын Говь-Алтай орон нутгийн хөгжлийн хөтөлбөрөөс олгосон багаж хэрэгслийг орлого аваагүй 0.4 сая төгрөгийн алдаа залрууллаа.

### 4.2 Төлбөрийн акт

Тушаал шийдвэргүй 0.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 4.3-т "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно.", 4.7-т "Энэ журмын 4.3-т заасан нөхцөлийг хангасан багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг тухайн сургалтын байгууллагын эрхлэгч, захирал гаргана. Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана." заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоолоо.

### 4.3 Албан шаардлага

- Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлаагүйгээр Төсвийн хөрөнгөөр 5.5 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"-ын 1.4-д заасан "Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу

зарлагдсанаас бусад авто машин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлан, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.1-д" Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож , урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ
- Хөндлөнгийн мэдээлэлтэй тулган баталгаажуулахад 425.3 мянган төгрөгийн түлш халаалтын өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтаж, тушаал шийдвэргүй үр дүнгийн урамшуулал олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-т "өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх", 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах заасантай нийцэж байгаа тул нягтлан бодогчид сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой

1.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим системд 352.9 сая төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 23.2 сая төгрөгийн 2 мэдээллийг ил тод байршуулаагүй, хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад

таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр " гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Есөнбулаг сумын 7 дугаар цэцэрлэг	6	6.2	1	0.4	1	0.3	3	5.5	1	
	Дүн	6	6.2	1	0.4	1	0.3	3	5.5	1	